УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН ТУШААЛ

2020 оны 05 сарын 01 өдөр Дугаар А/158 Улаанбаатар хот

Худалдан авах ажиллагаа зохион байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны "Нийслэлийн 2020 оны төсөв батлах тухай" 9/36 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2020 оны "Эрх шилжүүлэх тухай" А/543 дугаар захирамж, "Хот тохижилтын талаар авах зарим арга хэмжээний тухай" А/574 дугаар захирамж, "Эрх шилжүүлэх тухай" А/426 дугаар захирамж, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.2, 3 дугаар зүйлийн 3.1.10 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Засаг даргын 2020 оны "Эрх шилжүүлэх тухай" А/543 дугаар захирамжаар шилжин ирсэн "Сонгинохайрхан дүүргийн 17 дугаар хорооны 33 дугаар байрны гадна талбайн тохижилтын ажил" болон "Хот тохижилтын талаар авах зарим арга хэмжээний тухай" А/574 дугаар захирамжаар шилжин ирсэн "Хан-Уул дүүргийн 18 дугаар хороо, Их Жанжин Д.Сүхбаатарын хөшөөг шилжүүлэн байршуулж, сэргээн засварлах, хөшөө орчмыг тохижуулах ажил"-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахыг Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2020 оны А/60 дугаар тушаалаар байгуулагдсан Үнэлгээний хороонд, "Эрх шилжүүлэх тухай" А/426 дугаар захирамжаар шилжин ирсэн "Явган зам, чулуун замын ажил /БЗД, 13 дугаар хороо/"-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахыг Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2020 оны А/121 дугаар тушаалаар байгуулагдсан Үнэлгээний хороонд тус тус даалгасугай.

2. Сонгон шалгаруулалтыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж, зөвлөмжийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлж ажиллахыг Үнэлгээний хороо /М.Гансэлэм/, / Б.Номингэрэл / дод тус тус үүрэг болгосугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА Т.ГАНТӨМӨР

c:\users\gantuya\desktop\үж 12\doc 2020\тушаал 2doc.docx

1110320506